



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/676

Мөрөн сум

Журам, загвар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.17, 60.1.21 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын нарын ажлын үнэмлэх ашиглах журмыг нэгдүгээр хавсралтаар, ажлын үнэмлэхний загварыг хоёрдугаар хавсралтаар, ажлын үнэмлэхний бүртгэл хуудасыг захирамжийн гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гандэлгэр)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 28 өдрийн А/6.46
захирамжийн нэгдүгээр хавсралт

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН АЖЛЫН ҮНЭМЛЭХ АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ журмын зорилго нь сумын Засаг даргад ажлын үнэмлэх олгох, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Ажлын үнэмлэх олгох, хүчингүй болгох

2.1 Аймгийн Засаг дарга сумын Засаг даргыг батламжилж, шийдвэр гаргасан хугацаанаас хойш 1 сарын дотор, эсхүл томилогдсон даруйд сумын Засаг даргад ажлын үнэмлэх олгоно.

2.2 Ажлын үнэмлэхт аймгийн Засаг даргын гарын үсэг, тамга дарсанаар хүчин төгөлдөр болно.

2.2 Ажлын үнэмлэх нь нэгдсэн дугаартай байх ба бүртгэлийг тусгайлан хөтөлж, хадгална.

2.3 Сумдын Засаг дарга нарын ажлын үнэмлэхийг томилогдсон шийдвэр гардуулахдаа олгох, эсхүл тусгай хөтөлбөр гаргаж, ёслол төгөлдөр олгож болно.

2.4 Нэгдсэн байдлаар олгох тохиолдолд аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс зохион байгуулалтыг хариуцан ажиллана.

2.4 Ажлын үнэмлэхийг гээгдүүлсэн, устгасан тохиолдолд аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст албан бичгээр хүсэлт ирүүлж, хүсэлтийг үндэслэн үнэмлэхийг дахин олгоно.

2.5 Шинээр олгосон үнэмлэхний дугаар өмнөх үнэмлэхний дугаартай давхцахгүй ба гээгдүүлж, устгасан үнэмлэхийг хүчингүй тэмдэглэл бүртгэлд хөтөлнө.

2.2. Ажлын үнэмлэхийн хугацаа нь сумын Засаг даргын томилогдсон өдрөөс хүчин төгөлдөр болж, бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсноор хүчингүйд тооцогдоно.

2.5 Сумын Засаг даргыг ажлаас чөлөөлсөн шийдвэр гаргасанаар ажлын үнэмлэхийн хугацаа дууссанд тооцох ба үнэмлэхийг ажил хүлээлцэх комиссын даргад хүлээлгэн өгнө.


2.6 Комиссын дарга аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлнэ.

Гурав. Ажлын үнэмлэхийг ашиглах

3.1. Сумын Засаг дарга ажлын үнэмлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, төрийн захиргааны төв байгууллага, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, орон нутгийн агентлаг, байгууллага, сумдад албан ажлаар ажиллах, үйлчлүүлэх тохиолдолд ашиглана.

3.2. Ажлын үнэмлэхийг албаны үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

Аймгийн Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 28 өдрийн А/С.16
захирамжийн хоёрдугаар хавсралт



СУМЫН ЗАСАГ ДАРГЫН АЖЛЫН ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР

1. Ажлын үнэмлэх нь харьцаатай улаан өнгийн хавтастай хавтас гадна талд алтан Соёмботой шар өнгөөр ҮНЭМЛЭХ гэж бичигдсэн байна.
2. Ажлын үнэмлэхийн хавтасны хэмжээ өндөр нь 10.5, хөндлөн нь 7.2 см хэмжээтэй байна.
3. Ажлын үнэмлэхийн дотор талын нүүрний толгойн хэсэгт төрийн соёмбын зургийг голлуулан байрлуулна.
4. Баруун дээд буланд нэг өнгийн фон дээр албаны хувцастай сумын Засаг даргын 3х4 хэмжээтэй цээж зургийг байршуулна.
5. Цээж зургийн дор № гэсэн тэмдэг байх бөгөөд ажлын үнэмлэхийг Алаг-Эрдэнэ сумаас эхлэн 01 гэж сумын нэрсийн дарааллаар дугаарлана.
6. Ажлын үнэмлэх доторсумын Засаг дарга мөн тул үнэмлэх олгов гэж Word файлын Arial цэсээр үсгийн хэмжээ нь 12 –р дэвшүүлсэн үсгээр бичигдэнэ.
7. Ажлын үнэмлэх нь аймгийн Засаг даргын гарын үсэг, тамга дарагдсанаар баталгаажна.

Аймгийн Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын... өдрийн А/....
захирамжийн гуравдугаар хавсралт

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРЫН АЖЛЫН ҮНЭМЛЭХНИЙ БҮРТГЭЛ

№	Сумын нэр	Овог, нэр	Томилогдсон шийдвэрийн огноо, дугаар	Үнэмлэхний дугаар	Үнэмлэх олгосон огноо, дугаар	Хүчингүй тэмдэглэл